

БАТЛАВ.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Л.МӨНХЗУЛ

ATA12944 9132155 9024070683

**ХУРИМТЛАЛЫН САНГИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙН БОДЛОГЫН
ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХИЙН АЖЛЫН ДААЛГАВАР**

НЭГ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

Үндэсний баялгийн сангийн тухай хууль Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар батлагдсан. Хуулийн зорилт нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийн улсын төсөвт төвлөрсөн орлогыг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн санг байгуулах, сангийн эх үүсвэр, төрөл, зориулалтыг тодорхойлох, сангийн хөрөнгийг удирдах бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хуримтлалын сангийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:

- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1.-т “Хуримтлалын сангийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, батлагдсан төсвийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, сангийн үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэх”,
- 8.2.2-т “Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэж, хөтлөх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах”,
- 8.2.3.-т “энэ хуулийн 7.1.5-д заасан Монгол Улсын иргэн бүрд нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмыг боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх” зэрэг тус тус болно.

Тус хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэж, хөтлөх, сангаас зарцуулалт хийх, санхүүгийн тайланг боловсруулах үйл ажиллагааг удирдах системийг бий болгох, нэвтрүүлэх, системийн бүтэц, гүйцэтгэх үүрэг, санхүүгийн системийн үйл ажиллагааны хүрээг тодорхойлох, ажлын даалгаврыг боловсруулах, системийн хөгжүүлэлтийн явцад хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн систем нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4.1.6-д заасан “хуримтлалын нэрийн данс” нь энэ хуульд заасан эх үүсвэрээс Монгол Улсын иргэн бүрд жил бүр хуваарилсан мөнгөн хөрөнгө, үлдэгдэл мөнгөн хөрөнгөнд тооцогдох хүү, энэ хуульд заасан зориулалтын дагуу гаргасан зарлагыг нэгтгэн тооцсон Монгол Улсын иргэн бүрийн бүртгэлийг хэлнэ

гэж заасны дагуу Хуримтлалын сангийн тухайн жилийн орлого, уг орлогыг иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хуваарилах, хуримтлалын нэрийн дансны үлдэгдэлд хүү тооцож бүртгэх, Хуримтлалын нэрийн дансны мөнгөн хөрөнгийг гэр бүлийн гишүүнд шилжүүлэх, өвлөх, сангаас дэмжлэг авах хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх буюу эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар гүйлгээ хийх хүсэлтийг Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлэхтэй холбогдсон харилцаа болон Хуримтлалын нэгдсэн сангийн, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, судалгааны үзүүлэлт, иргэний хүсэлт, өргөдөл, гомдол хэрхэн хүлээн авах, шийдвэрлэх зэргийг багтаасан байна.

ХОЁР. АЖЛЫН ДААЛГАВРЫН ХАМРАХ ХҮРЭЭ

1. **Хуримтлалын нэгдсэн сангийн системийн ерөнхий бүтцийн саналыг боловсруулах.** Системийн оролцогч талуудыг тодорхойлж, бизнес процессын судалгааг хийсний үндсэн дээр системийн ерөнхий загвар бүхий техникийн даалгаврыг боловсруулна.
2. **Хуримтлалын нэгдсэн сангийн санхүүгийн системийн ажлын даалгавар боловсруулах.** Санхүүгийн системийн оролцогч талуудыг тодорхойлон системийн бүтцийг гарган, ажлын даалгаврыг боловсруулна.
3. **Хуримтлалын нэгдсэн системд иргэний хүсэлт, өргөдөл гомдол шийдвэрлэх системийн даалгавар гаргах.** Иргэний хүсэлт, өргөдөл гомдлын хүлээн процессыг хууль, журмын хүрээнд тодорхойлж системийн ерөнхий бүтэц болон ажлын даалгаврыг боловсруулна.

ГУРАВ. НИЙЛҮҮЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН

1. Хуримтлалын нэгдсэн сангийн системийн ерөнхий бүтцийн зураглал;
2. Хуримтлалын нэгдсэн сангийн санхүүгийн системийн ажлын даалгавар;
3. Хуримтлалын нэгдсэн сангийн системийн иргэний хүсэлт, өргөдлийн гомдол шийдвэрлэх системийн ажлын даалгавар.

ДӨРӨВ. ЗӨВЛӨХӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- ✓ *Боловсрол:* Дээд, эрх зүй, санхүүгийн удирдлагын чиглэлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй. Мэдээллийн технологи чиглэлээр мэргэшсэн бол давуу талтай гэж үзнэ.
- ✓ *Туршлага:*
 1. Мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай;
 2. Төрийн байгууллагын санхүүгийн системтэй холбоотой төсөлд ажиллаж байсан туршлагатай;
 3. Банк, санхүүгийн системийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- ✓ *Хэлний ур чадвар:* Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй
- ✓ *Мэргэшл:*
 1. Банк санхүүгийн үйл ажиллагаа удирдлагын чиглэлээр мэргэшсэн;
 2. Системийн шинжилгээний ур чадваруудыг эзэмшсэн;
 3. Системийн ерөнхий архитектур боловсруулах чадвар эзэмшсэн.
 4. Мэдээллийн сангийн удирдлагын программ хангамжийн мэдлэгтэй.